



**ХЯНАЛТЫН ХЭЛТЭС**  
**INTERNAL AUDIT DEPARTMENT**

*Шалгалтын илтгэх хуудас*

**Шалгалт хийсэн хугацаа:** Шивээ-овоо ХК-ийн Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд компанийн худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалтыг ХХ-ийн дарга Ц. Эрдэнэбатаар ахлуулан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн М. Мягмарсүрэн, техникийн хяналтын инженер Г. Наранбаатар нар хийж гүйцэтгэлээ.

**Шалгалтанд хамрагдсан хэсэг, нэгж:** Компанийн ХХХ

**Шалгалтанд хамрагдсан хугацаа:** 2015 оны 6 сарын 02-12 ны өдрийг дуустал.

**Зорилго:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан заавар, журмын хэрэгжилтэнд дүгнэлт гарган, гарсан алдааг засуулах, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллахад энэхүү хяналт шалгалтын зорилго оршино.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу явуулах бөгөөд энэхүү хяналт шалгалт нь хараат бус, шударга, ил тод байх зарчимаар холбогдох анхан шатны баримтад тулгуурлан хийнэ.

**Шалгалтын хэлбэр:** Төлөвлөгөөт шалгалт

**ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /ТБОНӨХБАҮХАТ/ хуулийн хэрэгжилт

Шивээ-овоо ХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан Тендерийн үнэлгээний хорооны 4 салбар комисс байгуулсан.

Тушаалын хавсралтын дагуу 47 тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2015 оны ерөнхий төлөвлөгөө [e-procurement.mof.gov.mn](http://e-procurement.mof.gov.mn) –ын [pmmis](http://pmmis) /худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт-шинжилгээний цахим/ сайтад байршуулсан.

Мөн тендерийн урилгыг [e-procurement.mof.gov.mn](http://e-procurement.mof.gov.mn) болон өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлдэг.

Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2015 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөвт өртгөөс хэтрүүлэн хийгдсэн худалдан авалт байхгүй.

- Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2015 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу баримтлах худалдан авах ажиллагааны журмыг харуулвал

Худалдан авах ажиллагааны журмын нэр	Төлөвлөсөн дүн /мян,төг/	Хэдэн удаа
Нээлттэй тендер шалгаруулалт	83 256 497,05	52
Харьцуулалтын арга	434 546,90	14
Шууд худалдан авах	187 820,20	23
<b><u>Нийт дүн</u></b>	<b><u>83 878 864,15</u></b>	

## 2. Үнэлгээний хорооны чиг үүрэг, түүний ажлын явц

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ил тод байдлыг хангах зорилгоор салбар комисс бүрт иргэдийн төлөөлөл 2 хүнийг оролцуулсан байна. Үнэлгээний хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй, сондгой тоотой байна.


Үнэлгээний хорооны хуралдаан хийх бүрт иргэдийн төлөөллийг оролцуулдаг тул ирц сайн гэж үзэж байна.

Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын үүрэг. Үүнд:

- хуралдааныг зарлан, мэдээлэх
- хавтаст хэрэг хөтлөн архивт хадгалуулах
- Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөх
- худалдан авах ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн талаарх

мэдээллээр гишүүдийг хангах

Тендерийн үнэлгээний хорооны 4 салбар комиссын ажлын явцыг харуулвал:



Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2015 оны ерөнхий төлөвлөгөө – нд тусгагдсанаар бүх тендерүүд зарлагдсан байх ёстой. Гэтэл 06 сарын 12-ны байдлаар 22 тендерийн урилгыг [e-procurement.mof.gov.mn](http://e-procurement.mof.gov.mn) сайтад зарлагдсан.

Энэ байдлаас дүгнэж харахад тендерийн үнэлгээний хорооны ажлын явц харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

### **3. Тендерийн баримт бичиг худалдсан бүртгэл, тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн бүртгэл, тендерийн нээлтийн тэмдэглэл**

Тендер нээх: хуулийн 26.1-ийн дагуу нээж, тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч оролцож байна.

06 сарын 09-ны өдөр компанийн төлөөлөгчийн газарт ажиллахдаа тендертэй холбоотойгоор хөтлөгдөх маягтуудыг үзэж шалгалаа. Үүнд:

- тендерийн баримт бичиг тараасан бүртгэл /тендерийн баримт бичиг худалдан авах тухай албан бичиг, кассын орлогын ордер/
- тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн бүртгэл
- тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн санлууд

06 сарын 10-ны өдөр компанийн төлөөлөгчийн газарт 2 Нээлттэй тендерийн нээлтэнд оролцож ажиллалаа. Үүнд:

- Ил тод, шударга явагдсан /хуулийн 26.3-ын дагуу тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, самбар дээр тэмдэглэл хөтөлж хэвшсэн/
- Самбар дээр тэмдэглэл хөтлөгдөж байгаатай зэрэгцэн “тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн санлууд” маягт болон нээлтийн талаархи тэмдэглэл хөтлөгдөн захиалагч байгууллагын төлөөлөгч болон оролцогчдын төлөөлөгч нар тэмдэглэлүүдтэй танилцан гарын үсэг зурж хэвшсэн байна.

Нээлт хийсэн тендер дээр тухайн тендерт оролцогчид төлөөлөгчөө суулгасан байна. Нээх үед хугацаа хожимдсон тендерээс татгалзах ёстой байгаа. /хугацаа хожимдсон тендер ирээгүй байсан/

#### **Дэвшилттэй талууд нь:**

Компанийн Төлөөлөгчийн газарт бичиг хэргийн ажилтантай болсноор дараах анхан шатны баримтын хөтлөлт болон захиалагч байгууллагын төлөөлөгч болон оролцогчдын төлөөлөгч нар тэмдэглэлүүдтэй танилцан гарын үсэг зурж хэвшсэн байна

- тендерийн баримт бичиг тараасан бүртгэл /тендерийн баримт бичиг худалдан авах тухай албан бичиг, кассын орлогын ордер/
- тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн бүртгэл
- тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн санлууд

Компанийн төлөөлөгчийн газрын бичиг хэргийн ажилтанд өмнөх шалгалтаар илэрч байсан алдааг дахин давтахгүй байх, тендертэй холбоотой анхан шатны баримтын хөтлөлтийг сайжруулах талаар мэргэжил, аргазүйн зөвөлгөөг өгч ажилласан. Мөн дээрх анхан шатны баримтыг эх хувиас нь хуулбарлан авч үлдэж хэвшсэн байна.

**Анхаарах асуудлууд нь:**

1. СЖЦ ХХК нь “Цахилгаан экскаваторын туслах тоноглол” нийлүүлэх тендерийн гэрээг 2015 оны 03 сарын 31 өдөр байгуулсан. Техникийн тодорхойлолтын дагуу сэлбэг хэрэгслийг гэрээ байгуулснаас хойш 21-30 хоногт нийлүүлэх хугацаатай бараа нийлүүлэлтийн хуваарь хийгдсэн. Гэтэл 2015 оны 06 сарын 10-нд эхний нийлүүлэлтээ хийсэн. Уг ирсэн сэлбэг хэрэгсэл дотор манай байгууллагаас алдагдсан 3 ширхэг 1080.33.24 эдийн дугаартай “Шайба” сэлбэг байсан. Зургийг хавсралтаар оруулав.
2. Нитро Сибирь Монголиа ХХК нь тендерийн гэрээг 2015 оны 04 сарын 28 өдөр байгуулсан. Техникийн тодорхойлолтын дагуу эмульсийн тэсрэх бодисыг нийлүүлэх гэрээ байгуулснаас хойш бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа 14-21 хоног, дараагийн татан авалт тухай бүрд захиалгын дагуу гэж бараа нийлүүлэлтийн хуваарь хийгдсэн. Гэтэл 2015 оны 05 сарын 15-нд эхний нийлүүлэлт болох 10 000 кг эмульсийн тэсрэх бодис Бласт ХХК-ийн агуулахаас нийлүүлэгдсэн. Мөн манай дараагийн захиалгын дагуу Бласт ХХК-ийн агуулахаас эмульсийн тэсрэх бодис нийлүүлэгдэх үйлдэл гарсан болно. ОХУ-аас эмульсийн тэсрэх бодис нийлүүлэхээр гэрээ хийгдсэн.
3. DM-45 өрмийн сэлбэг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт нь 4 сарын 18-нд тендерээ нээхэд оролцогч компани байхгүй, материал ирүүлээгүй тул дахин зарлана гэж байгаа нь хугацааг маш ихээр алдсан. Одоог хүртэл дахин зарлаагүй байна.

4. Тэсрэх бодис үйлдвэрт ачааны автомашин худалдан авахдаа нэг удаа НТШ шалгаруулалт хийгээд амжилтгүй болсон тул ШХА хийсэн байгаа. ШХА хийх болсон үндэслэлийн талаар ТехБХ-ээс тодорхойлолт авч хавсаргах шаардлагатай.
5. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2015 оны ерөнхий төлөвлөгөөнд зарим нэг НТШ-ыг орхигдуулсан байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2015 оны 01 сарын 20-ны өдрийн А/06 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын алдааг засварлах
6. Тос тосолгооны материалын тендерийн орлогыг Санхүүгийн программд бүртгэж авахдаа тосны нэр төрлийг нэмэгдүүлэхгүй гэдгээр өөр нэрээр орлогодсон байна.
7. Тос, тослох материал ихээр нийлүүлэгдсэний улмаас шатахуун түгээх станцын тос, тослох материалыг хадгалах саравчийн багтаамж хүрэлцэхгүй зориулалтын бус ил задгай газар хадгалсан. Энэ нь **“ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ”** хуулийн 11.1. *“Газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, саванд хадгална”* заалтыг зөрчсөн.
8. Хуучин сэлбэгийг тушаасан баримт дутуу.  
2015 оны 1 дүгээр сарын 14-нд ЭКГ5А №05 экскаваторын чиглүүлэгч дугуйнд сольж тавигдсан 1080-33-24 эдийн дугаартай 2 ширхэг шайба болон 2015 оны 04 сарын 13-нд ЭКГ5А №01 экскаваторын жилийн засварын үед тавигдсан 1080-33-24 эдийн дугаартай 4-н ширхэг шайбануудын тус тус хуучныг тушаасан баримт олдоогүй.
9. 2015 оны 5 дугаар сарын 3-ны 1 дүгээр ээлжинд зам усалгааны автомашин Terex №01 рулийн гидро насос ажиллагаагүй болж сэлбэгийн складаас 09062585 эдийн дугаартай шинэ рулийн гидро насос авч тавьсан. Санхүүгийн программ болон ТБХ-ийн ашиглалтын тоо бүртгэгчийн бүртгэлд дээрх сэлбэг эдийн дугаараар бүртгэлтэй байна.  
Үүнээс үзэхэд хэсэг нэгжүүдийн шаардах хуудсаар складаас гарсан сэлбэгүүдийг тухайн техник, тоног төхөөрөмжид тавигдсан эсэхийг таних боломжгүй байгаа бөгөөд сэлбэг, хэрэгсэл алдагдах боломжийг үүсгээд байна.

## **Цаашид авах арга хэмжээний санал:**

1. Шинээр ирсэн сериал дугаартай сэлбэг хэрэгслийн сериал дугаарыг болон өндөр үнэтэй сериал дугааргүй ижил төрлийн сэлбэг хэрэгслүүдийг тус тусад нь хувийн дугаартай болгож санхүүгийн программд бүртгэж орлогод авах.
2. Хэсэг нэгжийн механикууд техник, тоног төхөөрөмжийн засварын үед тухайн техникт шинээр тавьсан сэлбэг хэрэгслүүдийг зураг хэлбэрээр баримтжуулах. Шинээр тавигдсан сэлбэг хэрэгслийн сериал дугаар болон өндөр үнэтэй сериал дугааргүй сэлбэгийн хувийн дугаарыг хуучин сэлбэгийн тушаасан баримт болон сэлбэг хэрэгсэл авсан шаардах хуудсын хамт засварын тайланд тусгадаг болох.